



Цаг үе, үйл явдал

АРДЫН АРМИЙН 282 ДУГААР АНГИЙН 40 ЖИЛИЙН ОЙН “ДАЙЧИН НӨХӨРЛӨЛ” ДУРСАМЖ УУЛЗАЛТ БОЛЛОО



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	🌧️ 2


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.226	3.230
EUR 🇪🇺	3.265	3.275
CNY 🇨🇳	470	472
RUB 🇷🇺	50	50.20
JPY 🇯🇵	23.50	23.75
KRW 🇰🇷	2.39	2.41

ЗУРХАЙ



2022.08.31 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ГУРВАН ХӨХ УЛААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Бие эрхтний хүч сайжирна.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.09-19.37

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал: Гал

Энэ өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лус тахиу, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу.

Хол газраар яваар одогсод урд хойд мөрөө гаргавал зохистой.

Өнөөдөр буюу 8 дугаар сарын 31-ний өдөр **ҮБХИС-ийн жагсаалын талбайд Ардын армийн 282 дугаар ангийн 40 жилийн ойд зориулсан дурсамж уулзалт болж өндөрлөлөө.** Уг уулзалтад **ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан тэргүүтэй “АА-282” дугаар ангийн 1982 оны он жаууд оролцож, Тэмүүжин өрлөг дунд сургуулийн сонсогчдын үзүүлэх тоглолтыг үзэж сонирхсон юм.**



ИНЕГ-ын Захиргаа удирдлагын газрын дарга, бэлтгэл хурандаа Г.БАТЖАРГАЛ:

-18 насандаа эргэн очсон мэт санагдаж байна.

Өдгөөгөөс 40 жилийн өмнөх энэ өдөр 10 дугаар анги онц дүүргэсэн шилмэл 200 залуусыг Төв аймгийн Баянчандманьд шинээр байгуулсан Ардын армийн 282 дугаар ангид цэрэгт татаж байв. Эл анги нь “Гадаадын цэргийн академи”-д суралцагчдын бэлтгэлийг хангах, Монгол улсын Ардын армийг мэргэжлийн боловсон хүчнээр чанаржуулах зорилготой, батальоны хэмжээний томоохон зүйл байлаа. Миний бие Зөвлөлтийн нисэх хүчний дунд сургуульд тухайн үеийн Монгол Ардын армийн зэвсэглэлд байсан дуунаас хурдан МИГ-21 байлдааны сөнөөгч онгоцны нисгэгч гэх эрхэм хүндтэй мэргэжлийн эзэн болж суралцаж ирээд 1987 онд

Зэвсэгт хүчний 137 дугаар тусгай хороонд МИГ-21 онгоцны жагсаалын нисгэгчээр ажиллаж байсан. Сүүлд 1989 онд Ардын армийн цомхотгол өрнөж цэргийн боловсон хүчнийг улс, ардын аж ахуйн салбарт хуваарилах бодлогын хүрээнд МИАТ компанид шилжин ажиллаад өдгөө 15 жилийг үдсэн байна. Сайн хань, сайн аав байх, амьдралын хатуу хөтүүг туулахад нугаршгүй эр хүн байхыг эр цэргийн алба надад зааж сургасан гэж боддог. Миний ажил, амьдралын замнал өдий зэрэгтэй яваа минь энэ ангитай салшгүй холбоотой учир энэ ангиараа үргэлж бахархаж явдаг даа” гэлээ. Өдгөө Ардын армийн 282 дугаар ангийн 1982 оны төгсөлтөөс 3 генерал, 20 гаруй хурандаа бусад салбарт тэргүүлэх ажилтнууд төрөн гарчээ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 607,319,177

Эдгэрсэн

Нийт: 583,348,327

Нас барсан

Нийт: 6,492,384

Цаг үе, үйл явдал

24 БАЙЛДАГЧ, ТҮРҮҮЧ ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБАНД УЛИРАХ ХҮСЭЛТ ӨГЛӨӨ



Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа түрүүч, байлдагч нарт Зэвсэгт хүчний 350, 330 дугаар ангиас "Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба" сурталчилгааны арга хэмжээг энэ сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Сурталчлах өдөрлөгөөр

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Сүх-Очир, Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн Ажиллагааны удирдлагын тасгийн ахлагч, сургагч ахлагч Б.Баднаанямбуу нарын бүрэлдэхүүн хугацаат албаны дайчдад ангийн танилцуулга, цэргийн гэрээт

алба хаах эрх зүйн зохицуулалт, нийгэм хамгаалал, цалин хөлс, эдлэх боломжуудын талаар мэдээлэл хүргэсэн юм. Ялангуяа "Цэргийн гэрээт алба хаах журам"-д заасанчлан тэргүүний цэргийн гэрээт алба хаагчид хэдээд сургууль, дотоод сургалт дамжаанд суралцаж,

мэргэжил эзэмших, энхийг сахиулах ажиллагаа, бүтээн байгуулалтын ажилд оролцох боломж байдгийг онцлоод хугацаат албаны түрүүч, байлдагч нарын сонирхсон асуултад хариулсан юм. Энэхүү сурталчилгааны ажлын үр дүнд 24 хугацаат

цэргийн алба хаагчаас цэргийн гэрээт албанд элсэх хүсэлт гаргасан бөгөөд алба хаах гэрээний нөхцөлийг танилцуулж, мэдээлэл солилцов.

Дэслэгч Р.Билэг (Зэвсэгт хүчний 014 дүгээр анги)

16 БАЙЛДАГЧ ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБАНД УЛИРЧ, ТҮРҮҮЧ ЦОЛ ХҮРТЛЭЭ



Зэвсэгт хүчний 326 дугаар ангиас хугацаат цэргийн алба хааж байгаа түрүүч, байлдагч болон тэдний эцэг эх, арг гэрийн төлөөллийг урьж "Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба" сурталчилгааны арга хэмжээг өнгөрсөн 7 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан билээ. Сурталчилгааны арга хэмжээний хүрээнд 27 хугацаат цэргийн алба хаагчид цэргийн гэрээт албанд улирах хүсэлт гаргасан юм. Тэгвэл 8 дугаар сарын 30-ны энэ өдөр төлөөлөл болгож 16 байлдагч, түрүүчийг цэргийн гэрээт албанд элсүүлэх, Цэргийн тангараг давтах, цол олгох ёслолын ажиллагаа боллоо. Ангийн захирагч, хурандаа

Г.Отгонбаяр "Хугацаат цэргийн албанаас өөрсдийн хүсэл мөрөөдлийнхөө дагуу цэргийн албанд элсэж байгаа эрхэм дайчдадаа баяр хүргэе. Цэргийн гэрээт албаны эрх зүйн орчин жилээс жилд сайжирч, үүнд элсэх хугацаат цэргүүдийн тоо ч нэмэгдэж байна. Гэрээт цэрэгт өөрийгөө хөгжүүлэх, сурч боловсрох, энхийг сахиулах олон талын боломж бий. Эх орны тангараг дор амьдрах эгэлгүй сайхан албыг сонгосон та бүхний цаашдын ажил, амьдралд хамгийн сайн сайхныг хүсье" хэмээн баяр хүргэж, түрүүч цол олголоо.

Ахмад Л.Түмэндэлгэр (Зэвсэгт хүчний 326 дугаар анги)

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САРЫН АЯН

2022 онд Зэвсэгт хүчний 167 дугаар ангитай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу ангийн ажилтан албан хаагчдад Политехник коллежийн захирал Т.Буяндэлгэр болон байгууллагын мэргэжилтнүүд сэтгэлзүйн дархлаа, сэтгэл ханамжтай, аз жаргалтай ажиллах тухай, хугацаат цэргийн алба хаагчдад эерэг хандлага, бэлгийн боловсрол сэдвүүдээр сургалтыг тус тус зохион байгуулжээ.



ФОТО АГШИН



ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТӨЛӨӨЛӨЛ ХУВААРИЙН ДАГУУ "МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ" ДУРСГАЛЫН ХӨШӨӨНИЙ МОДЫГ УСАЛЖ, ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙВ.